



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

14191 Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг Бага тойруу 55
Утас 262449, 266246 Факс (976-11) 32 52 34

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙД Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

2021.08.23 № 1/595

Ганай -ны №

Г

Дэмжлэг хүсэх тухай

Монгол Улсын засгийн газрын 2020 оны 47 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын тохируулагч агентлаг-Биеийн тамир, спортын улсын хороо болгон өөрчлөн байгуулагдсан.

Биеийн тамир, спортын улсын хорооны байр болох "Спортын төв ордон"-нд 2009 оноос Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургууль байрлан сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулж байна.

Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хавсралтын 2.2.3-ын 2-т "Спортын төв ордон барих", 2.2.3-ын 4-т "Нийслэлийн спортын сургалттай дунд сургуулийн барилгыг" барьж байгуулах ажлыг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр тус тус батлагдсан.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт "Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрт зааснаас бусад тохиолдолд үндсэн үйл ажиллагаатай нь холбоо бүхий үйлчилгээ үзүүлдэг байгууллага, аж ахуйн нэгжээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг агентлагийн байранд байрлуулах"-ыг хориглодог. Мөн тус сургуулийн сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж буй Спортын төв ордны байрыг Монгол Улсын Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2012 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн "Барилгын төлөв байдлын тухай" 07-11/542 дугаар дүгнэлтээр "спортын ордны барилгыг цаашид ашиглалтын шаардлага хангахгүй" гэж тодорхойлсон.

Спортын төв ордон нь 1958 онд спортын тэмцээн зохион байгуулах, бэлтгэл-дасгалжуулалтын үйл ажиллагаа явуулах зориулалтаар баригдсан хэдий ч одоогоор Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургууль байрлан сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаа явуулснаар зориулалтын дагуу бүрэн ашиглах боломжгүй болсон.

Тодруулбал, ерөнхий боловсролын сургууль нь гадаад болон дотоод орчны стандартын шаардлага хангахгүй зориулалтын бус байранд сургалт-хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж хүүхдийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүсгэж байна.

Иймд Нийслэлийн ерөнхий боловсролын спортын төв сургуулийг өөрийн сургалтын байртай болох хүртэлх хугацаанд түр байршуулан сургалт-хүмүүжлийн үйл ажиллагааг хэвийн явуулах боломжийг судлан шийдвэрлэж өгнө үү.

Хувийг: Нийслэлийн Боловсролын газарт



ДАРГА

Ц.ШАРАВЖАМЦ

2021.08.23